

**Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний залуу ажилтанд
захирлын нэрэмжит грант олгох журам**

Нэг.Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмаар тус Хүрээлэнгийн залуу эрдэм шинжилгээний ажилтнуудын эрдэм шинжилгээ судалгааны ажлыг дэмжих, судалгааны үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор залуу судлаачдад Захирлын нэрэмжит грант (цаашид грант гэх) олгох, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. Грантын хэмжээ 2 сая хүртэл төгрөг байх ба жил бүр нэг удаа нэг судлаачид олгоно. Грант нь эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр буцалтгүй олгож байгаа мөнгөн тэтгэлэг юм.
- 1.3. Грантад эрдэм шинжилгээ судалгаа идэвхтэй гүйцэтгэж байгаа тус Хүрээлэнгийн 40 хүртэлх насны залуу судлаачид нэр дэвшүүлэх эрхтэй.
- 1.4. Грантыг судалгааны_ажилд зайлшгүй шаардлагатай тоног,төхөөрөмж, багаж хэрэгсэл, бусад материал, ном хэвлэл худалдан авах, гадаад болон дотоод томилолтын зардалд зарцуулж болно.
- 1.5. Нэг эрдэм шинжилгээний ажилтанд 2 жил дараалан грантыг олгохгүй.

Хоёр. Грантаар санхүүжүүлэх судалгааны ажлыг сонгон шалгаруулах

- 2.1 Нэр дэвшигч эрдэм шинжилгээний ажилтан дэвшүүлэх судалгааны төслийн материалыг тухайн жилийн 1-р сарын 20-ны дотор Хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн даргад ирүүлнэ. Судалгааны төсөл нь дараахи бүтэцтэй байна. Үүнд:
 - Төслийн нэр
 - Төслийн гүйцэтгэгчийн овог нэр, албан тушаал, мэргэжил, боловсролын зэрэг;
 - Төслийн эхлэх ба дуусах хугацаа;
 - Төсөл гүйцэтгэх үндэслэл ба шаардлага;
 - Төслийн эцсийн үр дүн;
 - Төслийн үр дүнгийн шинэлэг, дэвшилтэт тал;
 - Төслийн ач холбогдол, үр дүн;

Гурав. Грант олгох судалгааны ажлыг сонгон шалгаруулах

- 3.1. Грантыг шалгаруулах асуудлыг тус хүрээлэнгийн салбарын эрхлэгч нар болон эрдэмтэн нарийн бичгийн даргаас бүрдсэн ажлын хэсэг зохион байгуулах ба ажлын хэсгийг Хүрээлэнгийн Захирлын тушаалаар батална.
- 3.2. Дараах үзүүлэлтийг харгалзан Грант олгох төслийг шалгаруулна. Үүнд:
 - Судалгааны ажлыг гүйцэтгэх онол, арга зүйн түвшин, чадвар;
 - Судалгааны ажлын ач холбогдол, гарах үр дүн;
 - Судалгааны ажлын шинэлэг, дэвшилтэт байдал;
 - Судлаачийн үр чадвар, дадлага түршлага;
 - Судалгааны үр дүнг ашиглах хэрэглэх боломж.
- 3.3. Грант олгох судалгааны төслийг ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн Хүрээлэнгийн захирлын тушаалаар олгоно.

- 3.4. Грант авсан эрдэм шинжилгээний ажилтан нь үр дүнгийн тайланг хүрээлэнгийн захиргаанд ирүүлэх бөгөөд грант авсаны дараа жилийн нэгдүгээр сард багтааж уг ажлын үр дүнг хүрээлэнгийн нэгдсэн семинараар хэлэлцүүлсэн байна.